

ULAANBAATAR TRADE AND ECONOMIC
REPRESENTATIVE OFFICE IN TAIPEI

Suite 1112, 11th Floor, TWTC International Trade Building,
333 Keelung Road, Section 1, Xinyi District, Taipei 11012, Taiwan
Tel: 886-2-2722-9740, Fax: 886-2-2722-9745
E-mail: ubtrade.taipei@mfa.gov.mn

Selection of "Best Student" of 2024

- I. **Objective:** Taiwan accounts for 60% of global semiconductor supply and 90% of artificial intelligence chip production. Taiwan's information technology industry accounts for 86% of the domestic industry, and the development of the industry has been growing at an average rate of 15% in the past 10 years, and is expected to grow by about 18% in 2024. Due to the rapidly developing industry, there is an urgent need for Mongolia to train skilled professionals in this field, Ulaanbaatar Trade and Economic Representative Office in Taipei encourages Mongolian students to study in this field in Taiwan. Therefore, it has been decided to select 1 person, who is the best in academics and achievements among Mongolian students and young people who are successfully studying at the bachelor, master and doctoral level in Taiwan in the fields of information technology, artificial intelligence, and software development, as the "Best Student" of 2024, and will be awarded with a monetary reward. The award will be presented on November 22 during the "14th Gathering and Fun Competition for Mongolia Students in Taiwan".
- II. **Eligibility:** Mongolian students and young people studying information technology, artificial intelligence, and software at the bachelor's, master's, and doctoral level in Taiwan and working in Taiwan in this field.
- III. **Registration deadline:** November 8, 2024
- IV. **Documents to be submitted:**
 - 1) Written request for participation /Written and signed in Mongolian/
 - 2) Copy of passport
 - 3) Copy of student ID / Copy of the work ID
 - 4) Brief statement about achievements / Projects that the student has participated etc/

ТАЙБЭЙ ДАХЬ УЛААНБААТАРЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Suite 1112, 11th Floor, TWTC International Trade Building,
333 Keelung Road, Section 1, Xinyi District, Taipei 11012, Taiwan
Tel: 886-2-2722-9740, Fax: 886-2-2722-9745
E-mail: ubtrade.taipei@mfa.gov.mn

2024 оны “Шилдэг оюутан”-ы шалгаруулалт

- I. **Зорилго:** Тайвань дэлхийн хагас дамжуулагчийн нийлүүлэлтийн 60%-ийг, хиймэл оюун ухааны чип үйлдвэрлэлийн 90%-ийг эзэлж байна. Тайваний мэдээллийн технологийн салбар дотоодын үйлдвэрлэлийн 86%-ийг эзэлдэг бөгөөд салбарын хөгжил сүүлийн 10 жилд дунджаар 15%-ийн өсөлттэй явж ирсэн ба 2024 онд ойролцоогоор 18%-ийн өсөлттэй байх судлагаа гарсан байдаг. Хурдацтай хөгжиж буй дээрх салбарт чадварлаг мэргэжилтэн бэлтгэх шаардлага хэрэгцээ Монгол Улсад тулгарч байгаатай холбогдуулан, Монгол оюутан залуусыг Тайваньд энэ чиглэлээр түлхүү суралцахыг Тайбэй дахь Улаанбаатарын Худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газраас хөхүүлэн дэмжиж байна. Иймд 2024 онд мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан, програм хангамжийн чиглэлээр Тайваньд бакалавр, магистр, докторантурын түвшинд амжилттай суралцаж буй Монгол оюутан, залуусаас сурлага, амжилтаараа тэргүүлсэн 1 хүнийг 2024 оны “Шилдэг оюутан”-аар шалгаруулж, баярын бичиг, мөнгөн урамшууллаар шагнахаар шийдвэрлээд байна. Шагналыг 11 дүгээр сарын 22-ны өдөр “2024 оны Тайвань дахь Монгол оюутнуудын 14 дахь удаагийн чуулга уулзалт болон спорт өдөрлөг”-ийн үеэр гардуулна.
- II. **Тавигдах шаардлага:** Тайваньд мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан, програм хангамжийн чиглэлээр бакалавр, магистр, докторантурын түвшинд суралцаж буй болон энэ салбарт Тайваньд ажиллаж буй Монгол оюутан, залуус
- III. **Бүртгэлийн сүүлийн хугацаа:** 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр
- IV. **Бүрдүүлэх бичиг баримт:**
 - 1) Шалгаруулалтад оролцох өргөдөл /Монгол хэлээр бичиж, гарын үсэг зурсан байх/
 - 2) Гадаад паспортын хуулбар
 - 3) Их сургуульд суралцаж буй оюутны үнэмлэхний хуулбар, ажиллаж буй бол ажлын газрын үнэмлэхний хуулбар
 - 4) Үр дүнгийн талаар товч /суралцаж байх хугацаандаа хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар, ажиллаж буй бол ямар төсөл дээр ажиллаж байгаа болон үр дүнгийн талаар/